

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХАД БАГШ, ЭЦЭГ ЭХ, ОЛОН НИЙТИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Л.Сарангэрэл,

МУБИС-ийн Түүх нийгмийн ухааны сургууль

Abstract:

Nowadays, protection at child rights is a crucial issue of our society. Because the family is a primary environment for a child, its role and responsibilities are very important. Child rights to live, to on to be protected and to participate in social life are seriously determined by the family.

Түлхүүр үг: Хүүхдийн эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийн боловсрол, хүүхдийн эрхийн зөрчил эцэг эхийн хариуцлага

Сэдвийн зорилго:

1. Гэр бүл, эцэг эх хүүхдийн нийгэмшилтийн гол субъект болох нь ,
2. Эцэг эхчүүд хүүхдийн эрхийг хамгаалах талаар ямар үүрэг хүлээдэг вэ?
3. Эцэг эхчүүдэд эрхийн боловсрол олгох нь яагаад чухал вэ?
4. Эцэг эх, олон нийтэд нөлөөлөхийн тулд багш хүүхдийн эрхийг хамгаалах талаар юу мэддэг, чаддаг, ямар төлөвшилтэй байх ёстой вэ?

Төрөөс боловсролын талаар хэрэгжүүлэх баримтлах бодлогод “Боловсролын эрхэм зорилго”-ыг Хүн бүрийг оюуны зохих чадавхтай эрүүл чийрэг, хууль ёс, өөрийн болон бусдын эрхийг хүндэтгэн дээдэлдэг, үнэнч шударга, нийтэг эх орон, энх тайван байдал, эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг, гоо зүйн мэдрэмж таашаалтай, бие даан сурч, ажиллаж, амьдарч чадах иргэн болон төлөвшүүлэхэд чиглэн гэж тодорхойлсон байдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газраас Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хөгжил хамгааллыг сайжруулах олон талт хөтөлбөр, түүний хүрээний үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагааны нэг хэсэг бол гэр бүлд чиглэсэн хүүхэд хөгжил, хамгааллын асуудал юм. Тухайлбал, Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд өөрийгөө хөгжүүлж, ирээдүйд ажиллаж амьдрахад нь зайлшгүй шаардлагатай боловсрол, мэргэжил эзэмших орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний аж байдлыг улам сайжруулах үйл ажиллагааг гэр бүл, нийгэм, хамт олны хүрээнд төвлөрүүлэх нийгмийн шаардлагын үүднээс Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Засгийн газраас 2002 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Хүүхдийг гэр бүл, цэцэрлэг, сургууль болон нийгмийн орчинд цогцолбороор тасралтгүй сурган хүмүүжүүлэн, боловсрол мэргэжил эзэмшүүлж, амьдрал хөдөлмөрт бэлтгэх үндэсний системийг сонгон тогтоож, боловсролын системийг нийгмийн бусад байгууламжийн үйл ажиллагаатай нягт уялдаа холбоотойгоор хөгжүүлэх шаардлага даяаршлын өнөөгийн нөхцөлд бидний өмнө тулгараад байгаа билээ. Чухамхүү ингэж боловсролын системийг дангаар нь нь бус гэр бүл, сургууль, олон нийтийн байгууллагын уялдаа холбоон дунд нь авч үзэж хөгжүүлснээр өв тэгш иргэн төлөвших үндэс, суурь бүрэлдэх болно.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэгтэй холбогдохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлыг хөгжүүлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах чиглэлээр үндэсний болон орон нутгийн, мэргэжлийн байгууллагуудын түвшинд сургалт, семинар зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа бүрэн хэрэгжиж байна.

Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг УИХ-аас 2005 оны 10 сард баталсан. Энэхүү баримт бичигт гэр бүлийн ёс суртахуун, дэвшилтэд уламжлалыг дээдлэх, гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөдөөгийн гэр бүл, залуу гэр бүлийг


дэмжих гэр бүлд чиглэсэн нийгмийн үйлчилгээг сайжруулах асуудлыг бодлогын гол чиглэл болгон тодорхойлсон байна. (Хүүхдийн асуудлаарх үндэсний дээд хэмжээний чуулга уулзалт МУ-ын Засгийн газар УБ.,2004 х.52-61)

2005 оны 05-р сарын 26-нд Женевт болсон НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39-р. чуулганаас МУ-ын хэмжээнд “Хүүхдийн эрхийг хамгаалах” талаар дараах зөвлөмжийг хэрэгжүүлэхийн санал болгосон байна:

- Хүүхдийг гэр бүл, сургууль болон бусад байгууллагад хүүхдийг зодож шийтгэх, явдлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, мөн гэр бүлийн хүрээнд хүүхдийг зодож шийтгэхийг хуулиар бүрэн хориглох
- Ганц бие эцэг эхтэй гэр бүлд онцгой анхаарал хандуулах, тэд хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэхэд эцэг эх хоёулаа үүрэгтэй байх зарчмыг үндэслэн эцэг эхийн хамтын хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн хууль бодлого, боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдийг гэр бүлийн орчноос тусгаарлахгүй байхын тулд урьдчилан сэргийлэх яаралтай арга хэмжээ авах асрамжийн газарт байгаа хүүхдийн тоог бууруулах,
- Эцэг эхэд зориулсан сургалт, зөвлөгөө болон олон нийтэд түшиглэсэн хөтөлбөрөөр дамжуулан эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нараас хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд нь зохих тусламж дэмжлэг үзүүлэх,
- " Хүүхэдтэй зүй бусаар харьцах, хүчирхийллийн сөрөг үр дагавар, ноцтой уршгийг ойлгож түүнээс сэргийлэх талаар арга хэмжээ авч байгаа ч Дээрх асуудал байсаар байна.
- 2004 онд 5-р сард батлагдсан “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” хуулийг хэрэгжүүлэх хүүхдийг бүх төрлийн хүчирхийллээс бүрэн хамгаалах талаар бололцоотой бүхий л арга хэмжээг авах зэрэг олон асуудлыг бодтойгоор шийдэх зэрэг болно.

Эдгээр санал, зөвлөмжийг бид амьдралд хэрэгжүүлснээр хүүхдийн эрхийг нь хүндэтгэн дээдэлсэн гэр бүл, сургууль, нийгмийн орчныг бүрдүүлж, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг өндөрсгөх юм.

Ингээд хүүхдийн 4 үндсэн эрхэд тулгуурлаж дээрх асуудлуудыг авч үзье.



Хүүхдийн эдгээр эрхийг хамгаалагч нь түүний гэр бүл, сургууль, багш, олон нийт байдаг. Харин элгээр субъектуудаас багш бол хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар эцэг эх, гэр бүл, сургууль, олон нийтийн хооронд нь холбогч гүүр нь болж, ерөнхий зохицуулагчийн үүргийг хүлээх ёстой.

Өнөөдөр боловсролын салбарт хүүхдийн эрхийг хүндэтгэн дээдэлсэн нийгэм, гэр бүл, эрх зүйн орчин, хүүхдийн эрхийн боловсрол эзэмшсэн, түүнийгээ сургалт хүмүүжлийн үйл ажиллагаандаа бодитоор хэрэгжүүлэх эрхэд суурилсан боловсролын тогтолцоог хэрэгжүүлэх чадвартай багшлах боловсон хүчин зайлшгүй шаардлагатай байгаа юм. Дээр дурдсан бүх үйл ажиллагааг явуулах болон хэрэгжүүлэхэд боловсролын салбар тэр дундаа багш үүрэг их билээ. Багшаар дамжуулан боловсролын салбарт хүүхдийн эрхийг хүндэтгэж, хамгаалсан орчин нөхцөлийг сургууль төдийгүй түүний гэр бүл, хүрээлэн байгаа нийгмийн орчинд нь бий болгон бүрдүүлж болох юм. Ингээд багш хүүхдийн эрхийг хамгаалахад ямар үүрэг гүйцэтгэх талаар гэр бүл, олон нийтийн харилцаан дунд нь авч үзье.

Гэр бүл, эцэг эх хүүхдийн нийгэмшилтийн гол субъект болох нь.

Гэр бүл нь хүүхдийг нийгэмшүүлэх анхдагч орчин нь юм. Гэр бүл гэдэг нь нийгмийн жижиг хэсэг өвөрмөц маягийн бага бүлэг гэж сурган хүмүүжүүлэх ухаанд авч үзсэн байдаг. Хүүхэд бие хүн болж төлөвших явцдаа өөрийн гэсэн үнэт зүйлийн тодорхой үнэлэмж бүхий симпати (таашаах), антипатитай (үл таашаах) бүхий мэдрэмжтэй, зорилго чиглэлтэй, ертөнцийг үзэх үзэлтэй, зан үйлийн шалгууртай, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болон төлөвших ёстой. Энэ үйл явцад хүүхэд өөрийн гэр бүл, сургууль, нийгэм дэх соёл, зан үйл, мэдлэгийн хэм хэмжээнүүдийг өөрийн болгодог.

Гэр бүл бол нийгмийн үндсэн үүр бөгөөд ийм утгаар гэр бүлийг хөгжүүлэх ёстой. Гэр бүл бүх талаар хамгаалуулж, дэмжүүлэх эрхтэй. Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах, хүмүүжүүлэх, гол хариуцлагыг гэр бүл үүрнэ. Нийгмийн бүх институт хүүхдийн эрх, энх амар байдлыг хүндэтгэж, улмаар соёл, нийгэм, улс төрийн өөр системд өөр өөр хэлбэрийн гэр бүл байдгийг харгалзан хүүхэд айх аюулгүй, тогтвортой орчинд, аз жаргал дүүрэн, хайр халамжаар хүрээлүүлэн өсөж хөгжих бололцоо олгохын тулд эцэг эх, гэр бүл, хууль ёсны асрамжлагч болон хүүхдийг анхааран халамжлах үүрэг бүхий бусад хүмүүст зохих тусламж үзүүлэх ёстой гэж олон улсын хүүхдийн эрхийн конвенцод тусгажээ. (Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц х.24-25)

Туршилтын үндсэн дээр судлаачдын хийсэн дүгнэлтээс бүлгийн туршлагын тусламжтайгаар аливаа хүүхдийн дотоод шинж чанар бүрэлдэхийн хажуугаар түүнийг хүрээлэн байгаа нийгмийн шинжүүдийг өөрийн болгодог. Тухайлбал, Америкийн нэрт судлаач Ч.Кули олон төрлийн судалгаа хийсний дүнд хүүхдийн хүмүүжил, өөрийн “Би” гэсэн ойлголт нь урт удаан хугацааны зөрчилтэй процессын дүнд, бусад хүмүүсийн харилцан үйлчлэл социаль орчны нөлөөллөөр бий болдгийг тогтоосон байна. Ч.Кулигийн таамаглалаар “Би” гэдэг ойлголт нь түүнтэй харилцан үйлчлэлд орж буй хүмүүсийн хариу үйлдлээс хамааран бий болж төлөвшдөг ажээ. Хүүхдийн хувьд түүнтэй байнга харилцан үйлчлэлцэж, нөлөөлж байдаг гол субъект нь гэр бүл юм. Чухам иймээс гэр бүл нь хүүхдийн нийгэмшилтийн гол субъект болдог. (Наранбаяр. Г., Сарангэрэл.Л., "Социологи" УБ., 2004 х.50-55)

Сайн эцэг эх гэж хэн бэ? Хүн бүхэн сайн эцэг эх байхыг хүсдэг. Сайн эцэг эх байна гэдэг хамгийн нэр хүндтэй, хариуцлагатай өндөр шаардлага бүхий ажил юм. Эцэг эх, хүүхэд хоорондоо сайн харилцаатай бол хүүхэд өсгөн, хүмүүжүүлэх асуудал хялбар дөхөм болно. Энэ нь 2 талтай. Хүүхдийн хувьд өөрийгөө тайлбарлах, ойлгуулах, өөрийгөө нээж хөгжүүлэх эрхтэй. Харин эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн хүмүүжил зан төлөвийн тухайд юу нь зөв, юу нь буруу байгаа талаар зөвлөх, сургамжлах, хязгаар тогтоох эрхтэй. Энэ арга барилыг эерэг хүмүүжил гэж үздэг юм байна.

Эерэг хүмүүжлийн зарчмуудад дараах зүйлийг оруулан үзжээ:

- Хүүхэд эцэг эхтэйгээ харилцан ярилцах, хамтран ажиллах хүсэлтэй гэдэгт итгэ
- Хүүхдүүдийнхээ үгийг сонс
- Зан ааш, төлөвийн тодорхой хязгаар тавь
- Тууштай, тогтвортой бай
- Санал зөрөх явдлыг асуудал шийдэх чадварыг нь дээшлүүлэх боломж хэмээн үзэх хэрэгтэй

байдаг. (Бид үүнийг шийдэж чадна Эцэг эхчүүдэд зориулсан хүүхэд хүмүүжүүлэх зөвлөмж УБ., 2005 х.1-3) зэрэг болно.

Хэрвээ хүүхдээ сонсдог, ойлгодог байвал тэдний хүнтэй харилцах, ярилцах, зөвшилцөх, хэлэлцэх чадвар хөгжинө. Зөвшилцөл хэлэлцээрийн замаар асуудлыг шийдэх аргыг хүүхдүүд маань эцэг эх, биднээс сурах тул аливаа маргаан зөрчлийг хүч, заналхийлэл хэрэглэхгүйгээр шийдвэрлэх аргад тэднийг сургах нь зүйтэй юм. Гэвч энэ нь хүүхэд хүссэн болгоноо хийж, хүссэн болгоноо авна гэсэн үг биш юм. Зарим үед тэр болгон маргаад зөвшилцөөд байхгүйгээр, тэднээр ямар нэг юм хийлгэх

хүсэлт тавих болно гэдгийг хүүхдэд сайн ойлгуулах хэрэгтэй. Ер нь хүүхэд өөрийг нь сонсож, үзэл бодлыг нь хүндэтгэж байгааг мэдэрч байгаа нөхцөлд та ерөө тууштай байвал үгэнд ордог. Эерэг хүмүүжлийн зарчим баримтлан хүүхэдтэй харилцаж чадвал хүүхдийн эрхийг хүндэтгэн дээдэлсэн гэр бүлийн орчин бүрдэх юм.

Эцэг эхчүүд хүүхдийн эрхийг хамгаалах талаар ямар үүрэг хүлээдэг вэ?

Эцэг эх, гэр бүл нь хүүхдийн хууль ёсны асрамжлагч болон хүүхдийг анхааран халамжлах үүрэг бүхий бусад хүмүүс хүүхдийн энх амгалан байдлын төлөө гол үүрэг гүйцэтгэж гол хариуцлага хүлээнэ. Гэр бүл залуужихын хирээр эцэг эхчүүд үүргээ ухамсарлаагүйгээс янз бүрийн алдаа, дутагдал гаргах явдал сүүлийн үед их ажиглагдах болсон. Иймээс эцэг эхчүүдэд үүргийг нь ухамсарлуулах явдал чухал асуудлын нэг болоод байна. Эцэг эх гэр бүл, хууль ёсны асрамжлагч болон хүүхдийг анхааран, халамжлах үүрэг бүхий бусад хүмүүс хийгээд нийгэм бүхэлдээ хамтран хүүхдийн хүмүүжлийн төлөө хариуцлага хүлээдэг болгоход бидний бүх хөтөлбөр, баримталж буй байр суурь, бодлого тус дөхөм үзүүлэх ёстой.

Сурган хүмүүжүүлэх ухаан болон гэр бүлийг судлагдахуунаа болгон авч үздэг нийгмийн салбар шинжлэх ухаануудад гэр бүл дараах ерөнхий үүргүүдийг хүлээдэг болохыг илрүүлжээ.

- Хүмүүжүүлэх үүрэг
- Сэтгэл хөдлөлийн үүрэг
- Оюуны харилцааны үүрэг
- Нийгмийн анхан шатны хяналтын үүрэг
- Нөхөн үржихүйн үүрэг зэрэг (Ичинхорлоо.Ш., Сурган хүмүүжүүлэх ухаан УБ., 2003) болно.

Эцэг эхчүүд хүүхдийн эрхийг хамгаалах талаар Монгол улсын хуульд зааснаар дараах үүргийг хүлээдэг.

- Хүүхдийн амьдрах эрүүл, орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом, бусад шаардлагатай зүйлээр хангах,
- Хүүхдэд удам угсаагаа мэдүүлж, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг эзэмшүүлэх,
- Хүүхдэд эх орон, ард түмэн, эцэг эх, ах дүү, төрөл садан, бусад хүнийг хайрлан хүндэтгэн үзэл, үнэнч чанар, харилцааны соёл төлөвшүүлэх,
- Хүүхдийг архидах, мансуурахад донтох, садар самуунд автах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд өртөхөөс сэргийлэх, хамгаалах,
- Хүүхдийг сурган хүмүүжүүлэх, авьяас чадварыг нь хөгжүүлэхэд сургууль, хамт олон, хүүхдийн болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийн дэмжлэг туслалцааг авч, хамтран ажиллах
- Хүүхдийг эрүүл мэндийн болон хууль тогтоомжид заасан бусад даатгал эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах,
- Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх
- Хүүхэд журамт үүргээ биелүүлэхэд нь туслах,
- Хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас учруулсан хохирлыг заасан журмын дагуу арилгах, (Хүүхдийн эрхийг хамгаалах тухай)

Монгол Улсын Хуулиас...

Эцэг эхэд хүүхдийн эрхийн боловсрол олгох нь яагаад чухал вэ? Багшаас эцэг эхчүүдэд хүүхдийн эрхийн боловсрол олгох нь маш, чухал асуудлын нэг болоод байна. Яагаад гэвэл эцэг эхчүүд нэг талаасаа хүүхдийн эрхийг гол зөрчигч нөгөө талаас хүүхдэдээ хүний эрхийн хандлага төлөвшүүлэгч гол агент нь болдог. Олон нийт ч мөн адил.

Эцэг эхчүүдийн зүгээс хүүхдийн эрхийг зөрчдөг түгээмэл болон онцгой хэлбэрүүд:
Түгээмэл хэлбэрийн зөрчлүүд:

Хүүхдийн 4 үндсэн эрхийг хамгаалахад эцэг эхчүүдийн зүгээс гаргаж байдаг түгээмэл зөрчлүүд орно.

Онцгой хэлбэрийн зөрчлүүд:

- Хүүхдийг шоовдорлох
- Сэтгэл зүйн дарамт үзүүлэх, доромжлох

Тогтмол буюу ноцтой байдлаар хүүхэдтэй зүй бусаар харьцах буюу гадуурхан шоовдорлох, шоглох хүүхдийн сэтгэл санаа, зан байдлын төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхийг хэлнэ.

- Бие махбодын шийтгэл үзүүлэх

Жишээ нь: Хүүхэд зодуулснаараа муу хүн болдоггүй гэж эцэг эхчүүд ярьдаг. Энэ бол эцэг эхчүүд өөрсдийгөө хаацайлах гэсэн арга юм. Эцэг эхдээ зодуулж өссөн хүүхэд үр хүүхдээ бас зодож хүмүүжүүлнэ. Ингэснээр үе дамжсан хүчирхийллийг бий болгодог байна.

- Хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлүүлэх

Жишээ нь: Манай оронд хүүхдийг ажил, хөдөлмөр эрхлүүлэх явдал сүүлийн үед их нэмэгдэх боллоо. Энэ нь эцэг эхийн анхаарал, халамж суларч байгаатай холбоотой юм. Хүүхдэд далд хэлбэрийн дарамт шахалт үзүүлэх

Энэ хэлбэр нь сэтгэл санааны дарамтыг бодвол хүүхдийг гэмтээх, доромжлох гэсэн их хор уршигтай юм.

- Хүүхдийг хараа, хяналтгүй орхих

Жишээ нь: Судалгааны дүнгээс харахад 1990 оны байдлаар манай улсад 500 гаруй хараа хяналтгүй хүүхэд байсан гэсэн тоо баримт байгаа бөгөөд 1998 оны байдлаар 4000 болтлоо өсжээ. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн гуравны хоёр нь 90-ээд онд гарсан нийгэм эдийн засгийн өөрчлөлт нь тэдний ажил эрхлэлт улмаар амьдрал, гэр бүлийн харилцаанд хүчтэй нөлөөлсөн гэж үздэг. (Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг судалсан судалгааны тайлан х.35-38)

Эцэг эхээс хүүхдийн эрхийг зөрчихөд нь нөлөөлдөг хүчин зүйлс:

Санаатай болон санамсаргүй зөрчих тохиолдол:

1. Гэр бүл хүүхдийн эрхэд суурилсан мэдлэг, чадвар дутуугаас
2. Иргэний ухамсар төлөвшөөгүйгээс
3. Эцэг эхийн насны байдал
4. Санаатайгаар
5. Боловсролын түвшин
6. Амьдралын нөхцөл боломж хүрэлцээгүйгээс
7. Нийгэмд эзэлж буй байр суурь
8. Ажил эрхлэлт, орлого
9. Гэрлэлт болон гэр бүлийн харилцаа зэрэг олон хүчин зүйлээс болж гардаг. Эдгээр зөрчлийг гаргахгүй, багасгах явцад багш хэрхэн нөлөөлж болох талаар авч үзье.
1. Хүүхдийн эрх зөрчигдөж буй түгээмэл зөрчлийг багасгахын тулд:
 - "Ярилцлага, уулзалт зохион байгуулах /сургалт, семинар хийх/
 - Хамтарсан үйл ажиллагаа явуулах /Хүүхдийн эрхийн талаар зургийн уралдаан, зохион бичгийн уралдаан явуулах/
 - Мэдээлэл түгээх

2. Хүүхдийн эрх зөрчигдөж байгаа онцгой тохиолдолд багш:

Эцэг эхтэй нь ганцаарчлан уулзаж ярилцах, зөвлөх

- Хуулийн байгууллагад хандах хүүхдийн эрхийг хамгаалдаг бусад олон нийтийн байгууллагатай холбож өгөх, дэмжлэг үзүүлэх.

Багш хүн хүүхдийн эрхийг хамгаалах талаар юу мэддэг, чаддаг, ямар төлөвшилтэй байх ёстой вэ? Багш хүн хүүхдийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжид хүүхдийн хөгжил, хамгааллын талаар хэрхэн тусгасан болон төр засгаас энэ талаар ямар бодлого баримталж, үйл ажиллагаа явуулж байгаад дүгнэлт хийж тусгасныг мэдэж, түүнийхээ тусламжтайгаар эцэг эх, олон нийтэд нөлөөлөх ёстой.

Үндсэндээ сургуулийн удирдлага гэдэг нь хүүхэд, эцэг эхийн өмнө төрийн өмнөөс хариуцлага хүлээн, үйлчилгээ үзүүлэх, дээд шатны боловсролын салбарын удирдах байгууллагатай багш, эцэг, сурагчдыг холбож байдаг багш нарын нийлбэр цогц юм. Иймээс бид сургуулийн удирдлага гэдэг ойлголтыг багш гэсэн субъект дотор хамруулан ойлгох нь зүйтэй.

Хүүхдийн эрхэд суурилсан боловсрол гэж юуг ойлгох шаардлагатайг бид эхлээд тодорхойлох хэрэгтэй. Харин үүнийг хүүхдийн эрхийн боловсрол гэдэг ойлголтоос ялгаж ойлгох нь зүйтэй юм. Хүүхдийн эрхийн боловсрол гэдэгт хүүхэд өөрийн нийгмээс шаардах эрхтэй мэдлэгийн нийлбэр цогцыг хэлдэг бол хүүхдийн эрхэд суурилсан боловсрол гэдэг нь багш, эцэг эх сургууль, хамт олон хүүхдийн эрхийг хамгаалах талаар зайлшгүй шаардагдах, тэдгээрийн эзэмших ёстой мэдлэг, чадварыг оруулан ойлгоно.

Дээр бид хүүхдийн дөрвөн үндсэн эрх байдаг тухай ярьсан. Харин эдгээр эрхийг хамгаалах талаар багш юу хийж болох вэ, хүүхдийн гэр бүлтэй яаж хамтран ажиллах вэ, багш өөрөө ямар мэдлэг чадварыг эзэмшсэн байх шаардлагатай талаар ярилцъя.

АМЬДРАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Хүүхдийн үндсэн эрх бол амьдрах эрх байдаг. Амьдрах эрх гэдэг нь хүүхдийн үндсэн эрх бөгөөд энэ нь насанд хүрсэн хүний амьдрах эрхээс зарчмын ялгаатай байдаг юм. Насанд хүрсэн иргэн өөрийн амьдрах эрхийн төлөө өөрөө тэмцэх шаардлагатай байдаг бөгөөд тэрхүү эрхэд нь бусдын зүгээс ямар нэгэн байдлаар халдахгүй байхыг шаарддаг бол хүүхдийн тухайд түүний амьдрах эрхийг насанд хүрэгчид хангаж, хариуцаж байдаг билээ. Хүүхдийн амьдрах эрх гэдэг нь мэдээж хэрэг агаар амьсгалуулж, аманд нь хоол хийж байхыг хэлэхгүй. Тухайлбал хүүхдийн амьдрах эрхийн конвенцод түүнийг:

- нэгдүгээрт, тэрээр эрүүл саруул өсөж торних,
- хоёрдугаарт, аюулгүй орчинд аж төрөх,
- гуравдугаарт гэр бүл эцэг эхийн хайр халамжид байх

эрхтэй хэмээн нэрлэсэн байгаа юм. Харин энэхүү эрхийг хамгаалахад багш эцэг эх, гэр бүлтэй хамтран үүрэг хүлээдэг.

Үүний тулд мэдээж хэрэг хамгийн эхний ээлжид хүүхдийн эрхийн талаар төрөөс батлан гаргасан хууль тогтоомж, шийдвэр, бодлого үйл ажиллагааны үндсэн чиглэл болон олон улсын гэрээ конвенцод заагдсан зүйл заалтуудыг мэдэж байх хэрэгтэй болно. Харин эдгээр эрх зүйн орчны тухай баримт бичгүүд нь хүүхдийн эрхэд суурилсан боловсрол эзэмшихэд багшид туслах үүрэг гүйцэтгэнэ.

Хүүхдийн гэр бүлийн гишүүд, эцэг эхийн яс үндэс, боловсрол мэдлэг, мэргэжил, оршин суугаа орчин, нийгмийн гарал, ажил эрхлэлтийн байдал, орлого, мэдээллийн эх сурвалж зэрэг нь мэдээж хэрэг өөр өөр, харилцан адилгүй. Чухам энэл хүүхдийн эрхийг хамгаалахад багшийн гүйцэтгэх үүргийг илүү өндөрсгөх, нарийсгах үндсэн шаардлагын нэг болдог юм.

Иймээс багш зөвхөн өөрийн эзэмшсэн мэргэжлээс гадна олон төрлийн мэдлэг, чадвартай байхыг шаардаж эхэлдэг. Мэдээж хэрэг хүүхдийн амьдрах эрхийг сахин хамгаалагч гол субъект бол гэр бүл. Харин эцэг эх, гэр бүл хүүхдийн эрхийг хамгаалах талаар дээр өгүүлсэн янз бүрийн нийгмийн

өөр өөр статустай байдаг шалтгаануудын улмаас өөрсдөө ч анзаарахгүйгээр алдаа гаргаж байдаг. Тухайлбал хүүхдийн эрүүл, чийрэг өсөж бойжих зайлшгүй нэг нөхцөл

Болдог зөв хооллолт, хувцаслалт зэрэг энгийн нэгэн зүйлсийн талаар зарим эцэг эх мэдэхгүй тохиолдол нэлээдгүй байдаг шүү дээ. Эрүүл чийрэг өсөж бойжих нь хүүхдийн амьдрах эрхийн үндсэн гол хэсэг юм. Хүүхдийн амь насыг насанд хүрэгчдийн зүгээс санаатай бол санамсаргүй байдлаар хохироох, тахир дутуу болгох зэрэг нь хүүхдийн амьдрах эрхийг зөрчиж байгаа хамгийн ховор тохиолдол. Харин санамсаргүй байдлаар ч юм уу үнэхээр өөрийн мэдлэг дутагдсанаас тэдний эрүүл мэндийг хохироох, хохирч болзошгүй үйлд татан оруулах байдал Олон тохиолдолд ажиглагдаж байна.

Хүүхдийн хооллох, хичээллэх, амрах, биеийн хөдөлмөр эрхлэх зэрэг нь бүгд нас, оршин уугаа газар, орчин зэргээс хамааран янз бүр байдаг бөгөөд нарийн стандарттай. Эдгээр стандартыг ч багш мэдэж байхыг хүүхдийн эрхийг хамгаалах асуудал шаардаж байна. Үүгээр ч зогсохгүй тодорхой хэмжээгээр эрүүл ахуйн мэдлэгтэй байж, эцэг эх, гэр бүлтэй хамтран хуулийг ямарваа нэг болзошгүй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж байх хэрэгтэй. Үүнийг зөвхөн анги удирдсан багш ч бус харин сургуулийн удирдлага хамтран хэрэгжүүлнэ.

Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын тодорхойлсноор эрүүл гэдэг нь зөвхөн өвчингүй, бие бялдрын согоггүй байхын нэр биш харин бие, бялдар, оюун санаа, нийгмийн сайн сайхан байдал гэжээ. Олон улсын судлаач эрдэмтдийн тогтоосноор эрүүл мэндийн ойлголт бол нэлээд нарийн зүйл. Том хүнийхээс, хүүхдийн эрүүл мэндийг томъёолоход янз бүрийн насны хүүхдийн өсөлтийн шатуудад бие бялдар, оюун санаа, эрхтний тогтолцооны үйл ажиллагааны хөгжлийн түвшин, гадаад орчны хувьсан өөрчлөгдөж буй нөлөөлөлд бие бялдар, мэдрэл сэтгэцийн дасан зохицох үйл, зориудын бус болон дархлал хамгааллын төвшин зэргийг багтаадаг.

Шинжлэх ухааны дээрх таамаглалаар хүүхдийн эрүүл мэнд “эрүүл хүүхэд” гэдэг ойлголт нь удамшлын гадаад орчны хүчин зүйлийн нөлөөгөөр нөхцөлдөн биологийн насанд тохирч зохицсон амьдралын үйл ажиллагааны байдал, бие бялдар оюуны шинж төрхийн өв тэгш хөгжил, нэгдэл, хүүхдийн өсөлтийн явцад дасан зохицох урвалын бүрдлээр тодорхойлогдоно. Ийм учир хүүхдийн эрүүл мэнд нь юуны өмнө ах дүү, төрөл садан, гэр бүлийн эрүүл мэндийн төвшин, нийгэм эдийн засгийн эрүүл биш байдал, түүнийг төгс анагаахуй, улс орны соёл боловсролын хэмжээ, гадаад орчноос хамааран шалтгаалдаг байна. Үүнээс үндэслэн эрүүл мэндийн тухай ярихдаа бид бүх тохиолдолд хүүхдийн эрүүл мэндэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэйг онцлон тэмдэглэдэг.

Хүүхдэд эрүүл мэндийн ухаан суулгах дадал эзэмшүүлэхэд хүмүүсийн оролцоо, хувь

	3 нас	4-12 нас	13 нас
Эцэг, эх		50	25
Эмч		25	15
Багш	50	15	10
Хүүхэд өөрөө	50	10	50

(Эх сурвалж: Мухар.Ц Хүүхэд, Хөгжил, Хамгаалал)

Хүүхдийн эрүүл мэнд, амьдрах баталгааг хангах нөхцөл нь физиологийн эрэлт хэрэгцээнд тохирсон экологийн хувьд цэвэр хоол унд шимт бодис, байгаль, нийгмийн эрүүл аюулгүй, айдасгүй орчин, бие бялдрын чадавхад тохирсон хөдөлгөөн, эрүүл мэндийн тусламж баталгаатай байх болно. Нийгмийн амьдралын бүх орчинд хүүхдийн суурь эрэлт хэрэгцээний хангалтын асуудлыг эрэмбэ дараатай шийдвэрлэх шаардлагатай бөгөөд үр дүнг нь жишиг үзүүлэлтээр хянах шаардлагатай.

Дээр дурдсан энэ бүх асуудлаар багш, сургуулийн удирдлага нарийн мэдлэгтэйгээр няхуур, нямбай ажиллаж, хүүхдийн эрүүл мэндийн асуудлаар эцэг эх гэр бүлтэй тогтмол хамтран ажиллаж, хяналт тавьж ажиллах үүрэгтэй юм.

ХҮҮХДИЙН ХӨГЖИХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрх-ийг ч гэр бүлийн зүгээс зөрчих үзэгдэл түгээмэл байдаг. Жишээлбэл, ихэнх эцэг эх өөрийн хүүхдэд хичээл давтах, шинэ мэдлэг олж авахад нь туслалцаа үзүүлэхгүй, хайхрамжгүй ханддаг. Энэ нь хүүхдийн эрхийг зөрчиж байгаа түгээмэл хэлбэрийн нэг юм. Энэ бүх зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд эцэг, эх гэр бүлийн зүгээс хүүхдийн сургалт, хүмүүжлийн ажилд багшаас дутахгүйгээр оролцож, үүргээ бие, шаардаж, ухамсарлуулж байх үүрэгтэй болдог.

Хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах талаар ямар арга хэмжээ явуулбал олон нийтэд хүртээмжтэй болох, тэрхүү арга хэмжээг хэрхэн зохион байгуулах арга барилд суралцах нь багш хүнд чухал шаардлагатай.

Хүүхэд түүний дотор өсвөр насныхан, өсөж хөгжихийнхөө хирээр өөрийн санаа бодлыг чөлөөтэй илэрхийлэх, эрх эдлэн өөрийгөө хүндэтгэх, хүмүүжилтэй болж амьдралаа зорилтыг хэрэгжүүлэхийн тулд тухайлбал, зөрчил мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэр гаргах харилцахад холбогдолтой эрдэм мэдлэг, барил дадал эзэмших боломжтой байх ёстой. Хүүхэд түүний өсвөр насныхны санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүүхдийн эрхийг хүн дэмжих ёстой бөгөөд хүүхдийн нас боловсролын байдалд тохируулан тэдний санал зохих ёсоор харгалздаг байх хэрэгтэй. Хүүхэд залуучуудын, өөрийн орчин тэдний өвлөн авах нийгэм ертөнцийг төлөвшүүлэхэд идэвхтэй оролцох боломж олгохын тулд тэдний эрчим хүч уран бүтээлийг сайшаан дэмжих хэрэгтэй. Гадуурхагдсан, шоовдор хүүхэд, өсвөр насныханд үндсэн үйлчилгээг хүргэх, өөрийгөө хүндэтгэдэг болгон хүмүүжүүлэх, амь насаа өөрснөө хариуцаж чаддаг болгоход бэлтгэхийн тулд тусгайлан анхаарч дэмжих хэрэгтэй байна. Бид шийдвэр гаргах, тэр дундаа гэр бүл, сургууль болон үндэсний хэмжээнд шийдвэр гаргах үйл явцад хүүхэд, насныхныг биечлэн оролцуулах хөтөлбөр боловсруулан хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц х.31-32)

ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх сурган хүмүүжүүлэх ухаанд боловсрол сургууль багш нар болон төрөлх гэр орон, хайр халамжтай эцэг эхээс нь илүүгээр үе тэнгийнхэн хүчтэй нөлөөлдөг. Хүүхэд муу нөлөөнд орж сурлага хүмүүжлээр доголдохоос гадна сайн талаар найз нөхдөөсөө үлгэр дуурайл авдаг жишээ олон байдаг. Үүнээс үзвэл сайн ажиглаж бодлого зорилготой жолоодож чадвал хүүхдийн хөгжил, төлөвшилд найз нөхөд, хүүхдийн өөрийн хамт олон нь сурган хүмүүжүүлэх асар их чадавхтай гэдэг нь харагдаж байна. Жил бүр орон даяар олон хүүхэд хамарч явагддаг байсан уламжлалт арга хэмжээнүүд хүүхдийн авьяасыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй ашиглах, тэдэнд бага наснаас ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэхэд илүү нөлөө үзүүлсэн гэдгийг хүүхэдтэй ажилладаг бүх хүмүүс өндөр үнэлдэг бөгөөд одоо ч зарим нь үргэлжлэн явагдсаар байна. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ийн конвенцын 15-р зүйлд хүүхэд сайн дураар эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах эрхтэйг тусгайлан заасан. Өнөөдөр дэлхийн зуу гаруй оронд скаутын, пионерын, шонхрын, байгаль сонирхогчдын, зуны зуслангийн, өсвөрийн техникчдийн, аялал жуулчлалын хүүхдийн өөрийн удирдлагын гэх мэтээр хүүхдийн төрөл бүрийн байгууллага, хөдөлгөөн олон сая хүүхдийг хамран ажиллаж байна.

Эдгээр нь хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхийг хамгаалах, баталгаажуул онцгой нэг хэлбэр юм. Хүүхдийн байгууллага хөдөлгөөн нь хүүхдийг субъект болгон сургалт хүмүүжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулдаг. Энэ чанараараа хүүхдийн өөрийн удирдлага, идэвх санаачилга, бие даасан үйл ажиллагааг хүүхдийн байгууллага, хөдөлгөөн хамт олон эрчимтэй хөгжүүлдэг. Мөн хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг

баримжаа олгох, чөлөөт хөгжлийн шалгарсан сайн аргын нэг болж байна. Нийгмийн идэвхтэй гишүүн болох иргэний ухамсар төлөвших, хүүхэд хамт олонч, үзэл дархлаа тогтоох үндсэн нөхцөлийг хүүхдийн байгууллага бүрдүүлдэг. Ийм учраас хүсэл сонирхол, авьяас чадвар, амьдралын орчин нас биеийн онцлог байдлаар ойртон нэгдсэн хамт олон байгууллага, хөдөлгөөн найз нөхөд нь хүүхдэд юугаар ч сольшгүй үнэт зүйл юм. Ямар ч эцэг эх, багш харьяат хүүхдээ хамт олноос нь найз нөхдийн хүрэнээс нь салган авч ганцааранг нь шилмэл хүн болгон төлөвшүүлнэ гэдэг бүтэшгүй хэрэг.

Иймийн учир сургуулийн удирдлага, багш ямагт хүүхдийн байгууллага хөдөлгөөн, хамт олон хөгжихөд дэмжлэг туслалцаа үзүүлж санал зөвлөгөө, арга зүйн удирдлага үзүүлэн, эцэг эх гэр бүлийг өөрийн хүүхдээ дээрх хөдөлгөөнүүдэд хамруулах талаар хамтран ажиллаж байх нь хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн үйл ажиллагааны нэг болно.

ХҮҮХДИЙН ХАМГААЛАХ ЭРХИЙН ТАЛААР

Хүүхдийн хамгаалуулах эрх төрийн бодлогын багц хуульд үндсэндээ хүүхдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж байна гэж ойлгож болно. Хүүхэдгүйгээр боловсрол гэж байхгүй гэж дээр дурдсан билээ. Харин эдгээр хүүхдийн эрх ашгийг шууд болон тойруу замаар хамгаалж байгааг онцлон тэмдэглэе. Хүүхэд нийгмийн орчинд хөгжиж бие хүн болон төлөвшихөд олон хүчин зүйлүүд нөлөөлдөг. Эдгээрийн дотроос хамгийн гол хүчин зүйл нь сургалт хүмүүжлийн нэгдмэл үйл явц юм. Энэ нь өөрийн гэсэн өвөрмөц орчинд явагддаг. Өөрөөр хэлбэл сургалт хүмүүжлийн үйл явц нь өөрийгөө дэмжин тэтгэх зохистой орчинд явагдаж байж сая үр дүнд хүрнэ. Үүнтэй уялдан сургалт, хүмүүжлийн орчинд гэсэн ухагдахуун, сурган хүмүүжүүлэх ухаанд зохих байр эзлэх болсон. Сурагчийн сурч мэдсэн зүйл нь үзэл санаанд нь итгэл үнэмшил болж, хүүхэд өөрөө хүний амьдралын ёсонд суралцаж байвал хүмүүжилтэй болдог. Сурагчийн хүмүүжил төлөвшилд нийгмийн орчны олон хүчин зүйлүүд нөлөөлдгийн дотор чухал нөлөөтэй хоёр хүчин зүйл байдаг. Энэ нь удамшил, орчин 2 юм.

Хүүхдийн эрхийг хамгаалах талаар сонирхлын бүлгүүдийн хамтын ажиллагааг:

- Багш, олон нийт
- Эцэг эх, олон нийт
- Сургуулийн удирдлага, олон нийт
- Олон нийт гэж 4 ангилна.

Багш, сургуулийн удирдлагаас эцэг эх болон олон нийтэд хүүхдийн эрхийн талаар мэдлэг олгох арга замууд:

- Таниулан ойлгуулах

Бүх хүмүүст хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай, хүүхдэд учирч болох эрсдэлийн талаар ойлгуулан таниулна.

- Урьдчилан сэргийлэх

Таниулан ойлгуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулснаар ажилтнууд болон бусад хүмүүс зохих ойлголт, мэдлэгтэй болж, хүүхдэд учирч болзошгүй эрсдэлийг багасгана.

Мэдээлэх

- Хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлөх аливаа асуудал гарсан тохиолдолд хэнд мэдээлэх, ямар арга хэмжээ авах тухай ажилтнууд болон бусад хүмүүс тодорхой мэддэг байна.

Арга хэмжээ авах: Хүүхэд дарамт, хүчирхийлэлд өртсөн буюу өртөж болзошгүй нь мэдэгдвэл хүүхдийн хамгаалах, дэмжиж туслах арга хэмжээг авна. /Хүүхдийг хамгаалах бодлого Хүүхдийг Ивээх сан/ /Их Британи/

Багш хүүхдийн эрхийг хамгаалах талаар эцэг эхэд чиглэсэн үйл ажиллагааны талаар:

- Нүүр тулсан ярилцлага хийх /ангийн хурал, эцэг эхийн зөвлөл/
- "Арга хэмжээ зохиож урьж оролцуулах
- Судалгаа хийх /Анги суралцагчдын талаар/
- Сургалт зохион байгуулах
- Багш эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран хүүхдийн эрхийг хамгаалах талаар заавар зөвлөгөө өгөх

Багш “Хүүхдийн эрхийг хамгаалах” талаар төрийн болон төрийн бус байгуул хамтран олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааны талаар;

- **Уулзалт-чөлөөт ярилцлага зохион байгуулах**

Энэ үйл ажиллагаа нь хүүхдийн эрхийн тодорхой асуудлаар хэсэг бүлэг хүмүүсийн товч илтгэл санаа бодлыг сонссоны дараа оролцогчид асуулт асууж, өөрсдийн сан илэрхийлэх байдлаар явагдана. Ингэснээр уулзалтад оролцогчид бие биеэ сонсох нэг нэгнээсээ суралцах, ялангуяа хүүхэд залуучууд, багш сурагчид эцэг эх, олон нийт харилцаа санал бодлоо солилцох боломж нээгдэнэ. Олон нийтэд мэдээлэл сурталчилгааны материал тараах,

- **Хүүхдүүдийн дунд зурагт хуудас, зургийн үзэсгэлэн зохион байгуулж оролцох**

Энэ нь хүүхэд, залуучууд бусад ямар ч хүмүүст санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгодог сонирхолтой арга хэмжээ юм. Тухайлбал: Хүүхдийн эрхийн талаар суралцагчид өөрсдийн санаа бодлыг илэрхийлсэн зураг зурах, түүгээр нь үзэсгэлэн гаргаж олон нийтэд хүргэх,

- **Соёл, хүмүүжлийн ажил зохион байгуулах**

Энд урлагийн нэгдсэн арга хэмжээ, спортын арга хэмжээнүүд орно. Урлаг, уран сайхны дотроос дуу, шүлэг, хөгжим, жүжиг, хошин шог, бүжиг зэрэг нь хүмүүст ялангуяа хүүхэд залуучуудад мэдээлэл хүргэх сонирхолтой хэлбэр бөгөөд хоорондоо илэн далангүй яриа өрнүүлэх, дотоод сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмжийг илэрхийлэх боломж олгоно.

- **Маргаан, чуулган бүлгийн ярилцлага**

Маргаан, чуулган бүлгийн ярилцлага зэрэг нь тодорхой асуудлаар санаа бодлоо солилцох, нэгдсэн ойлголтод хүрэх сонирхолтой арга хэмжээ юм. Эдгээр арга хэмжээнд төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс, тэрчлэн янз бүрийн бүлгийн хүмүүс оролцох боломжтой байдаг. Жишээ нь: залуучууд, өсвөр насныхан, багш, эцэг эхчүүд, олон нийтийн идэвхтнүүд гэх мэт.

- **Асуулт хариултын тэмцээн**

Асуулт хариултын тэмцээн нь оролцогчдод тодорхой сэдвээр, зохих мэдлэг олгох сонирхолтой хэлбэр юм. Тухайн сэдвээр мэргэжлийн хүмүүс, мэргэжилтнүүд, хүүхэд залуучууд, оюутан, сурагчид, хүмүүст яриа таниулга хийх, зөвлөгөө өгөхийн өмнө энэ арга хэмжээг хэрэглэж болно. Асуулт хариултын гол зарчим нь оролцогчдод асуулт тавиад хөтлөгч хэд хэдэн хувилбарын хариулт өгнө. Оролцогч зөв хариултыг олж хэлэх ёстой.

Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн эдгээр арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулж чадвал хүүхдэд ээлтэй орчин нөхцөл бүрдүүлж болох юм.